



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэмандал сумын “Арсаравч” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/04/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.Open.audit.mn Архангай аймаг 2025 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор П.Цэцэгдулам Утас: 7033-3019 Цахим хаяг: Tsetsegdulam@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	6
5.1 Албан шаардлага	6
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	7

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.05.20 № 148
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН
“АР САРАВЧ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.БАТСҮХ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Ар саравч” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангаас өмнөх онд авч хувь хүнд шилжүүлсэн зээлийн тайлант оны хүүгийн авлагыг тооцож бүртгээгүй, 64,946.4 мянган төгрөгийн үндсэн зээл, хүү 904.7 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.5, 3.4.11, 10.1, 11.3 ,

Хоршоог хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний 9.2 дахь заалтыг зөрчсөн, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6,600.00	37,600.00
1.1.2	Дансны авлага	66,000,000.00	65,851,100.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	66,006,600.00	65,888,700.00
1.30	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	66,006,600.00	65,888,700.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	66,000,000.00	65,851,100.00
2.1.1.1	Дансны өглөг	66,000,000.00	65,851,100.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	66,000,000.00	65,851,100.00
2.20	Өр төлбөрийн нийт дүн	66,000,000.00	65,851,100.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	6,600.00	37,600.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,600.00	37,600.00
2.40	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	66,006,600.00	65,888,700.00

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		1-р сарын 1	12-р сарын 31
8	Бусад орлого	66,030,000.00	1,210,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	1,179,000.00
12	Бусад зардал	66,023,400.00	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	6,600.00	31,000.00
19	Орлогын татварын зардал	-	3,100.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	6,600.00	27,900.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	6,600.00	27,900.00
24	Орлогын нийт дүн	6,600.00	27,900.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	66,030,000.00	1,210,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	66,030,000.00	1,210,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	66,023,400.00	1,179,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	66,023,400.00	1,179,000.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,600.00	31,000.00
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,600.00	31,000.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,600.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,600.00	37,600.00

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,600.00	6,600.00
9	2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	6,600.00	6,600.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	31,000.00	31,000.00
17	2024 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	37,600.00	37,600.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа залруулаагүй. Харин залруулагдаагүй 65,851.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг 1 зөрчилтэй асуудал 65,851.1 мянган төгрөг бөгөөд тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 429.2 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Тус газрын өмнө нь ажиллаж байсан дарга нь 2023 онд сумын хоршоо хөгжүүлэх сангаас мах боловсруулах үйлдвэр байгуулах төслөөр 66,000.0 мянган төгрөгийн 5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй зээлийг “Ар саравч” ОНӨААТҮГ-ын харилцах дансаар дамжуулан авч, хувь хүмүүсийн дансанд шилжүүлэн зарцуулсныг тус ОНӨААТҮГ-ын балансад хувь хүнээс авах авлагаар, харин хоршоо хөгжүүлэх санд өгөх өглөгөөр тус тус бүртгэсэн байна. Тайлант онд хувь хүнээс авах авлагын үлдэгдэл (үндсэн зээл 64,946,400 төгрөг, зээлийн хүү 904,700 төгрөг) нийт 65,851.1 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх санд төлөх урт хугацаат зээлийн өр 65,851.1 мянган төгрөгөөр тайлагнасан байна. Тухайн авлагыг өмнө нь даргаар ажиллаж байсан иргэнээс авч, өр төлбөрийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, байгууллагыг өр төлбөрт оруулж хохирол учруулж болзошгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.5-д “Зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх”, 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 10.1-д “Хяналтын зөвлөл нь зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлж буйд хяналт тавина”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” Хоршоог хөгжүүлэх сангаас олгох зээлийн гэрээний 9.2-т “Хэрэв зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй ... эргэн төлөлтийн графикайг 3 удаа зөрчсөн тохиолдолд зээлийн гэрээг цуцалж ... зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбар болон энэ гэрээнд заасан алдангийн хамт төлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлээ.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Авлага, өглөгтэй холбоотой	1	65,851.1			1	65,851.1						
Нийт дүн	1	65,851.1			1	65,851.1						